

≡ **Өдрийн Тойм**

● **Нийгэм**

● **Улс төр**

● **Бизн**

Дэлхий


Шинээр гаргах 80 вакцинаас эхнийх нь ОХУ-д VI.15-нд “МЭНДЭЛНЭ”

Админ

2020-04-21 10:18



Австри улсын Эмнэлгийн технологийн Үнэлгээний институтын (АИНТА) гаргасан эрдэм шинжилгээний тоймоос харахад, Дэлхийн хэмжээнд коронавирусийн эсрэг 155 нэр төрлийн эм, 80 вакциныг гаргаж авахаар эрдэмтэн мэргэд ажиллаж байгаа ажээ. Эмийн ихэнх нь “эбола” гэх мэт бусад вирусийн өвчнийг урьд өмнө нь эмчлэхэд хэрэглэж байсан, олон улсад зөвшөөрөгдсөн нэр төрлийнх.

f Эдгээр эмийг одоо COVID-19-өөр өвчлөгсдөд хэрэглэхэд хэр нөлөөтэй болохыг тогтоохоор  судлан шинжилж байгаа гэнэ.

 Шинээр гаргаж авахаар шамдаж байгаа 80 нэр төрлийн вакцин нь өнөөдөртөө үр дүнгээрээ хэрэглэх түвшинд албан ёсоор баталгаажуулаагүй байна. Гэхдээ эдгээр вакцинаас манай хойд хөршид анхных нь “мэндэлж” эмчилгээнд хэрэглэх магадлалтай боллоо. ОХУ-ын Эпидемиологи, микробиологийн үндэсний судалгааны төвийн захирал Александр Гунзбург “Коронавирусийн эсрэг вакциныг сайн дураар туршилтад орохыг зөвшөөрсөн 180 хүнд 6 дугаар сарын 1-нээс тарьж судалгаа хийнэ. 6 дугаар сарын 15 гэхэд эмийн улсын бүртгэлийн жагсаалтад оруулж COVID-19-өөс урьдчилан сэргийлэх эмчилгээнд хэрэглэж эхэлнэ” гэж мэдэгдэв.

Эх сурвалж: udriintoim.mn

СЭТГЭГДЛҮҮД